



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ  
ТОГТООЛ

2014 оны 06 сарын 03 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

**Хуулийн заалтыг хэрэгжүүлэх тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.4 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэгт заасныг үндэслэн Өргөдлийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.8 дахь хэсгийн "Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан тухайн жилийн эмчилгээний төлбөрийн хэмжээнээс давсан хэсэг болон магадлан итгэмжлэл бүхий эмнэлгийн байгууллагын шийдвэрээр гадаад оронд эмчлүүлэх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд зардлынх нь 60-аас доошгүй хувийг төр хариуцах" гэсэн заалтыг хэрэгжүүлэх талаар Засгийн газарт /Н.Алтанхуяг/-т дараах чиглэлийг өгсүгэй:


1.1.Төрийн албаны тухай хуулийн 27.1.8 дахь заалтыг хэрэгжүүлэх журмыг батлан мөрдөж ажиллах;

1.2.Төрийн албаны тухай хуулийн 27.1.8 дахь заалтыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн улсын төсвийн тухай хуульд тусган батлуулж байх;

1.3.Төрийн албан хаагчдаас энэ талаар гаргасан гомдлыг судлан үзэж, барагдуулах арга хэмжээ авах.

2.Тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллан 2014 онд багтаан тус Байнгын хороонд танилцуулахыг Засгийн газар /Н.Алтанхуяг/-т даалгасугай.

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА



Р.БУРМАА